



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 606

Улаанбаатар хот

Г Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.1, 6.4.2, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Хотын стандарт, хяналтын газрын улсын байцаагчийн 2023 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 02-13-01/037/57 дугаар дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болох нь тогтоогдсон, нийт 18,998,081.00 (арван найман сая есөн зуун ерэн найман мянга наян нэгэн) төгрөгийн балансын үнэ, 8,055,210.45 (найман сая тавин таван мянга хоёр зуун арван төгрөг дөчин таван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төгсдэлгэр, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал С.Өнөрсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө акталж данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Акталсан барилга байгууламжийн доорх газар эзэмших эрхийг төрийн байгууллагын мэдэлд хэвээр үлдээж, нөхөн сэргээх, зориулалтын дагуу ашиглах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ
123006574
31-r huraldaan.docx


 Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн
 дугаар тогтоолын хавсралт
НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЭДЭСНИЙ ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/Д	Хөрөнгийн нэр	Ашиглаалтад орсон огноо	Тоо хэмжээ /ширхэг/	Нэг бурийн балансын үнэ /төгрөг/	Балансын нийт үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/ /төгрөг/	Үндэх өргтөг /төгрөг/
2	Зүлэгжүүлсэн талбай	1973.01.25	50	5,965.00	298,250.00	298,250.00	-
4	Агуулах	2018.12.31	1	17,663,495.00	17,663,495.00	7,627,418.38	10,036,076.62
5	Харуулын байр	2018.12.31	1	1,036,336.00	1,036,336.00	129,542.07	906,793.93
		52	18,705,796.00	18,998,081.00	8,055,210.45	10,942,870.55	
				(арван найман сая есөн зуун ерэн найман мянга наян нэгэн төгрөг Нийт дүн Нийт дүн	(арван найман сая есөн зуун мянга хоёр зуун арван төгрөг дөчин таван мөнгө)	(арван сая есөн зүйн дөчин хоёр мянга найман зуун далан төгрөг тавин таван мөнгө)	(арван сая есөн зүйн дөчин хоёр мянга найман зуун далан төгрөг тавин таван мөнгө)